



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

12  
АНГИ

# МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....

#### Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 22 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

#### **Мөнгөний саятан биш, эрүүл мэндийн саятан болцгооё (эсээ)**

*Зуун хорь наслахад зургаахан юм дутаж байна  
Дотоод бохирдолтын хөдөлгүүрээ цэвэрлэцгээе*

Монголчуудын одоогийн байдлыг ажиглахад мөнгөний хойноос таварцаглан таварцаглан зүтгэж байх нь олонх харагдана. Эд баялгийн хуримтлал бус, эрүүл мэндийн хуримтлал хийх нь хамгийн дээд баян болох гол болзол юм. Үүнийг яаж хийх вэ? Онолын хувьд хүн бүр л урт наслахыг хүсдэг. Тэгсэн мөртөө амьдрал дээр амьд явах насаа өөрснөө богиносгоод байдаг. Ийм гажиг зангаа таягдан хаях нь урт наслах эрүүл мэндийн хөрөнгө хуримтлуулах гол нэг болзол юм.

Амаараа бид урт наслах, сайхан амьдрах тухай гоё үгийг гадагш нь үргэлж гаргаж байдаг. Мөн тэр амаараа насаа богиносгох, эрүүл мэндээ хөнөөх юмыг дотогш нь үргэлж оруулж байдаг.

Хоол хүнс! -Амаар маань чөлөөтэйгөөр барахгүй бид бүхний хамгийн их дур сонирхол, хүсэл мөрөөдөл, урилга заллагаар өдөр бүр нэвтрэн орж буй цэцгийн тос, маргарин тос бусад өөх тосны зүйл гэхэд л ходоодонд орсон хойно нь боловсруулахад даруй 150 хэмийн илч дулаан шаарддаг. Гэтэл бидний биеийн маань илч халуун сайндаа л 36 хэм гаруйхан (36.6) байдаг шүү дээ. Хоолоо шингээх гэж мөн ч их илч (биеийнхээ халуунаас бараг 5 дахин илүү) ялгаруулах шаардлагатай болох нь ээ. Тэгэхээр ядралгүй яах вэ. -Амаар маань чөлөөтэйгөөр барахгүй хамгийн хүслэнт «зочин» болон байнга нэвтрэн ордог ёотон, алаг чихэр, цагаан талх, давс, хүрэн бурам (шоколад), зайрмаг тэргүүтэй амттанууд нь ходоодонд хүрэхийн тулд урт (12 метр урт) зам туулахаас гадна тэдгээр нь үйлдвэрлэл, худалдааны хор агуулсан байх тул эрүүл мэндийг яваандаа хөнөөдөг нь үнэндээ хүн тийнхүү алгуурхан замаар амиа хорлож буй хэрэг юм. Ийм болохоор «эд мөнгөний саятан биш эрүүл мэндийн саятан л» зуун хорь наслах хувьтай.

Зуун хорь наслахад зургаахан юм ихэнх хүнд дутагдсаар байдаг билээ. Эрүүл мэндийн саятан болохын тулд: нэгдүгээрт хоолны дэглэм хоёрдугаарт нар салхи, гуравдугаарт хөдөлгөөн, дөрөвдүгээрт цэвэр ус, тавдугаарт өлсгөлөн буюу мацаг, зургаадугаарт баясгалан энэ зургаан дутуугаа гүйцээх хэрэгтэй юм. Эрүүл мэндийн саятан болоход тус хүргэх, бас 120 наслахад дутаж байгаа дээр дурдсан 6 зүйлийн нэгээс бусад нь хүмүүст ойлгомжтой бөгөөд хэвшүүлэхэд төвөггүй зүйл. Харин тавдугаар зүйл буюу өлсгөлөн гэгчийн тухайд тогтож ярих нь чухал. Өрнөдөөр өлсгөлөн гэж нэршсэн энэ зүйл бол монголчуудад маш эртний мэддэг байсан танил нь мөн. Түүнийг мацаг барих хэмээдэг байлаа.

-«Соёлтой өлсгөлөн!» Түүнийг ухаарснаар хүн дахин залуужиж чадна гэж мэдэгдсэн юм. Соёлтой өлсгөлөнгийн ачаар хүн наад зах нь 120 наслах болно гэж тэр үзэж өөрийн биеэр үлгэрлэсэн байна. Поль Брегийн «Дотоод хордлогоос» ангижирч дахин залуужих хөтөлбөр нь долоо хоног бүр 24-36 цагийн өлсгөлөн өөртөө зарлах, жилдээ нийт дүнгээр 52 өдөр өлсгөлөн амьдрах ердөө л иймхэн зүйл юм. Эхлээд 3 хоног өлсөх хэрэгтэй. Тэгэхдээ нэрмэл ус байнга ууна. Дараа нь хүнсний ногоо дагнан идэж өдөр бүр 40 хэмийн халуун усанд 10 минут орно. Явган явна. Ингэж бэлтгэсний дараа долоо хоног бүр 24-36 цаг буюу нэг хоног гаруйн хугацаанд юм үл иднэ. Нэрмэл усаа л ууна. Өлсгөлөн нь хүний биед нэвчсэн хорыг хөөн гаргана. Эхний үед (3 хоногт) хэн ч тэсэхүйеэ бэрх хэцүү юм шиг санагдана. Тэр үеийг заавал даван туулах эр зориг гаргах хэрэгтэй. Тэрийг тэсэж өнгөрөхгүй бол өлсгөлөн үр дүн олохгүй. Тэсэж давснаас хойш бие хөнгөрч, ухаан санаа саруул болж баяр баясгалан өөрөө ирнэ. Бөөрөөр дамжин

гарсан литр ус бүр нь биеэс 90 грамм хорт ялгадсыг гадагшлуулдаг байна. Өвчин тусах бүх шалтгааны 99 хувь нь хоол хүнснээс үүдэлтэй байгааг өнөө үед шинжлэх ухаан нарийвчлан тогтоосон учраас «хоолны хордлого» гэдгийг пологтох, гүйлгэхээс илүү өргөн утгаар ойлгох хэрэгтэй юм.

...Сүүлийн үед «өлсгөлөн зарлах» талаар монголчууд шинэ зуршилтай болоод байгаа. Тэр бол улс төрийн утгатай өлсгөлөн. Тийм өлсгөлөнгөөр эрүүл мэндийн хөрөнгө биш улс төрийн хөрөнгө хуримтлуулахыг оролцдог болжээ. Харин эрүүл мэндийн өлсгөлөн бол өлсгөлөн биш мацаг юм. Мацаг бариваас нас уртасна.

Өөрөө өөртөө өлсгөлөн зарлавал зарлатугай! Тэгвэл 120 нас наслах болно.

*Л.Түдэв, 1998 он*

### **Монгол хэлний даалгаарууд**

1. Эсээний хөтөч санаа аль вэ?
  - A. Зуун хорь наслахад зургаахан юм дутаж байна. Дотоод бохирдолтын хөдөлгүүрээ цэвэрлэцгээе.
  - B. Монголчуудын одоогийн байдлыг ажиглахад мөнгөний хойноос таварцаглан таварцаглан зүтгэж байх нь олонх харагдана.
  - C. Эд баялгийн хуримтлал бус, эрүүл мэндийн хуримтлал хийх нь хамгийн дээд баян болох гол болзол юм. Үүнийг яаж хийх вэ?
  - D. Онолын хувьд хүн бүр л урт наслахыг хүсдэг.
2. Эсээнд толгой өгүүлбэр болж чадахгүй байгааг олоорой.
  - A. Амаараа бид урт наслах, сайхан амьдрах тухай гоё үгийг гадагш нь үргэлж гаргаж байдаг. Мөн тэр амаараа насаа богиносгох, эрүүл мэндээ хөнөөх юмыг дотогш нь үргэлж оруулж байдаг.
  - B. Хоол хүнс! -Амаар маань чөлөөтэйгөөр барахгүй бид бүхний хамгийн их дур сонирхол, хүсэл мөрөөдөл, урилга заллагаар өдөр бүр нэвтрэн орж буй цөцгийн тос, маргарин тос бусад өөх тосны зүйл гэхэд л ходоодонд орсон хойно нь боловсруулахад даруй 150 хэмийн илч дулаан шаарддаг.
  - C. Зуун хорь наслахад зургаахан юм ихэнх хүнд дутагдсаар байдаг билээ.
  - D. -«Соёлтой өлсгөлөн!» Түүнийг ухаарснаар хүн дахин залуужиж чадна гэж мэдэгдсэн юм.
3. Эсээнд дэвшүүлсэн асуудлыг олоорой.
  - A. Монголчуудын одоогийн байдлыг ажиглахад мөнгөний хойноос таварцаглан таварцаглан зүтгэж байх нь олонх харагдана.
  - B. Дотоод бохирдолтын хөдөлгүүрээ цэвэрлэцгээе
  - C. Зуун хорь наслахад зургаахан юм дутаж байна
  - D. Мөнгөний саятан биш, эрүүл мэндийн саятан болцгооё
4. Эсээний гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
  - A. ...Сүүлийн үед «өлсгөлөн зарлах» талаар монголчууд шинэ зуршилтай болоод байгаа.
  - B. Харин эрүүл мэндийн өлсгөлөн бол өлсгөлөн биш мацаг юм.
  - C. Өөрөө өөртөө өлсгөлөн зарлавал зарлатугай! Тэгвэл 120 нас наслах болно.
  - D. Өвчин тусах бүх шалтгааны 99 хувь нь хоол хүнснээс үүдэлтэй байгааг өнөө үед шинжлэх ухаан нарийвчлан тогтоосон

5. Зохиолч “хүн алгуурхан замаар амиа хорлож байна” гэсэн үзэл бодлоо аль хэсэгт илүү тодоор илэрхийлсэн бэ?
- A. ёотон, алаг чихэр, цагаан талх, давс, хүрэн бурам (шоколад), зайрмаг тэргүүтэй амттанууд нь ходоодонд хүрэхийн тулд урт (12 метр урт) зам туулна
  - B. ёотон, алаг чихэр, цагаан талх, давс, хүрэн бурам (шоколад), зайрмаг тэргүүтэй амттанууд нь үйлдвэрлэл, худалдааны хор агуулсан байх тул эрүүл мэндийг яваандаа хөнөөдөг
  - C. амаар маань чөлөөтэйгөөр барахгүй хамгийн хүслэнт «зочин» болон байнга нэвтрэн ордог амттанууд нь үйлдвэрлэл, худалдааны хор агуулсан байх тул эрүүл мэндийг яваандаа хөнөөдөг
  - D. Хоолоо шингээх гэж мөн ч их илч (биеийнхээ халуунаас бараг 5 дахин илүү) ялгаруулах шаардлагатай болох нь ээ.
6. “Бөөрөөр дамжин гарсан литр ус бүр нь биеэс 90 грамм хорт ялгадсыг гадагшлуулдаг байна” гэсэн баримтын хэлбэрийг зөв тодорхойлсныг олоорой?
- A. Тодорхой хугацаанд ажиглаж хэмжээсжүүлсэн учраас судалгааны
  - B. Польш Бреггийн судалгаанаас хэсэгчлэн хуулж авсан тул эшилсэн
  - C. Үнэн зөв мэдээллийг дамжуулж байгаа учир бодит байдлын
  - D. Тодорхой тоон дээр үндэслэн нэгтгэн дүгнэсэн учраас тоон
7. Зохиогч “Ийм гажиг зангаа таягдан хаях нь урт наслах эрүүл мэндийн хөрөнгө хуримтлуулах гол нэг болзол юм.” гэсэн нь ямар ямар чадварыг хэлж байна вэ?
- A. Тунгаан бодох чадвар
  - B. Өөрийгөө хөгжүүлэх чадвар
  - C. Бусдыг ойлгож хүндэтгэх чадвар
  - D. Өөрийгөө хянах чадвар
8. Амттануудын талаар чи зохиогчтой санал зөрөлдөж байна. Тэгвэл доорх үзэл бодлуудаас аль нь чинийх вэ?
- A. Дэлхийн олон хүнийг тэжээхийн тулд амттанд нэмэлт зүйл хийхээс өөр аргагүй.
  - B. Тогтвортой хөгжил талаасаа дэлхий ертөнц ганцхан надад заяагаагүй гэдгийг хүлээн зөвшөөрч, амттан үйлдвэрлэлийг багасгах нь зөв.
  - C. Хүний амьдрал ганцхан, амттайг идэж сайхныг өмсөж, сайныг эдлэх нь нэг амьдарч байгаагийнхаа идийг бүтээсэн хэрэг.
  - D. Амттан бүр гадна сав баглаа дээрээ орц найрлага нь тодорхой байдаг тохируулаад хэрэглэх, эс хэрэглэх нь хувь хүний асуудал.
9. “Тэсэж давснаас хойш бие хөнгөрч, ухаан санаа саруул болж баяр баясгалан өөрөө ирнэ.” гэсэн өгүүлбэр дэх таслалын үүргийг тодорхойлбол?
- A. Бүтээврийг зэрэгцүүлэн тоочих
  - B. Өгүүлбэрийг зэрэгцүүлэн тоочих
  - C. Үгийг зэрэгцүүлэн тоочих
  - D. Холбоо үгийг зэрэгцүүлэн тоочих
10. **“Тэтэл** бидний биеийн маань илч халуун сайндаа л 36 хэм гаруйхан (36.6) байдаг шүү дээ.” өгүүлбэрийн холбох үгийн үүргийг олоорой.
- A. Эсрэгцүүлэн холбох
  - B. Лавшруулан холбох
  - C. Угсруулан холбох
  - D. Онцлон холбох

**Үндэсний бичгийн даалгаврууд**

11. Цээрлэх ёстой холбоотой өгүүлбэрийг зөв уншаарай.

۱۱. ۱۱. ۱۱  
 ۱۱. ۱۱. ۱۱  
 ۱۱. ۱۱. ۱۱  
 ۱۱. ۱۱. ۱۱

- A. Амсар нь эмтэрхий аяганд цай хийхийг цээрлэдэг.
- B. Амсар нь эвдэрхий аяганд цай хийхийг цээрлэдэг.
- C. Амсар нь эмтэрхий аяганд цай хийхийг цааргалдаг.
- D. Амсар нь эвдэрхий аяганд цай гээхийг цээрлэдэг.

12. Монгол хэлний тухай хуулийн заалтыг уншиж буруу хөрвүүлсэн үгтэй хэсгийг ол.

12. 12. 12  
 12. 12. 12  
 12. 12. 12  
 12. 12. 12  
 12. 12. 12  
 12. 12. 12  
 12. 12. 12  
 12. 12. 12  
 12. 12. 12

- A. 11.1.1.Монгол улсын Засгийн Газар
- B. монгол хэлний талаар төрийн
- C. бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг
- D. зохион байгуулж, хангах үүрэгтэй

13. “бусдын сануулгаар бурууг засах зарчим” гэсэн холбоо үгийг үндэсний бичгээр зөв бичсэнийг олоорой.

A. 13. 13. 13  
 B. 13. 13. 13  
 C. 13. 13. 13  
 D. 13. 13. 13

14. “математик” хэмээх гадаад үгийг зөв бичсэнийг олоорой.

A. 14. 14. 14  
 B. 14. 14. 14  
 C. 14. 14. 14  
 D. 14. 14. 14

15. “Омогтой тархинд .....  
Овтой тархинд .....” зүйр үгийг гүйцээж бичээрэй.

A.	B.	C.	D.
سختتر و بهتر بمستتر و بهتر	نصير و بهتر بمختر و بهتر	بها و بهتر بمخير و بهتر	بمستتر و بهتر بمن و بهتر

**Уран зохиолын даалгаврүүд**

16. Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” романы “Олноо өргөгдсөний дөтгөөр оны зуны эхэн сарын нэгэн өдөр Их Тамирын хойгуур гарсан замаар гуч орчим насны хар хүн нэлээд ачаатай морин тэрэг хөтлөөд явж байв” гэсэн хэсгийн хам сэдвийг тодорхойлоорой.
- A. улс төрийн хам сэдэв
  - B. нийгмийн хам сэдэв
  - C. шашны хам сэдэв
  - D. түүхийн хам сэдэв
17. “Дэвхрэг” гэж хэний хоч нэр вэ?
- A. Ч.Галсан “Аянгат цагийн тууж”-ийн Доёбуу
  - B. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир”-ын Итгэлт
  - C. С.Дашдооров “Бууж мордох хорвоо”-ийн Ангаа
  - D. С.Эрдэнэ “Өвгөн шувуу”-ны Жамц
18. Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” романы Итгэлтийн хөрөнгөжих эх сурвалж юу вэ?
- A. Эцгээс уламжилсан өв хөрөнгө бага байсан нь
  - B. Арван есөн насандаа Лувсан тайжийн охиныг ёслон авсан нь
  - C. Лувсан тайжийн охиныг ёслон авч өмчид нь овоо мал авсан нь
  - D. Гаднаа цөөн мал байлгаж бусдыг ядуучуудад өгч хариулгадаг нь
19. “Итгэлтийн бүл гэвэл эхнэр Должин, арван настай хүү Хонгор, долоон настай охин Солонго ийм дөрвөн халуун амь билээ” өгүүлбэрт ямар дүрслэх ур маяг байна вэ?
- A. төлөөлөл
  - B. адилтгал
  - C. тойруулал
  - D. юмшуулал
20. “Шүлэглэсэн зохиолын авианы тогтолцоо, түүний загвар, зүй тогтлыг судалдаг шүлэг судлалын салбар ухааныг.....гэнэ” цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.
- A. эгшиглэл зүй
  - B. бадаглал зүй
  - C. айзам зүй
  - D. аялгуу зүй

